

“ҮНЭГЭН САН” БА МОНГОЛЧУУДЫН БЭЛГЭЗҮЙН ҮНЭГ

С.Бямбадорж

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны сургууль, Угсаатан судлалын тэнхим

Түлхүүр үг: үнэг, заль, сан, өргөл

Монголд нэлээд тархсан зан үйлийн судрын нэг нь “Үнэгний сан”гийн судар билээ. Одоогоор энэ сангийн монгол, тод бичгийн хувилбар судар Ордос, Халх, Баруун Монголоос олдсон байна. Энэ талаар нэрт монголч эрдэмтэн В.Хайссиг, Х.Серриус, Ч.Бауден, судлаач У.Эрдэнэтуяа нар судалгааны өгүүлэл бичиж, олон эрдэмтэд зохиол бүтээлдээ дурдсан байдаг. Дээрх эрдэмтдийн судалгааны бүтээл болон Монгол улсын УТНС-ийн гар бичмэлийн фондод хадгалагдан байгаа таван хувилбар монгол бичгийн эхийг харьцуулан “Үнэгэн сан”гийн судалгаанд үг нэмэрлэх дашрамд монголчуудын бэлгээгүй дэх үнэгний тухай үзэл төсөөллийн талаар саналаа хэлэхийг зорьлоо.

Судалгааны агуулгаас үзэхэд, судлаачид уг судрыг буддын шашны нөлөө туссан бөө мөргөлийн судар, төвд хэлнээс орчуулсан хэмээн үзэж байна. Тэд Мачен бомра уул болон бусад төвдийн газар усны нэр, галигаар бичсэн “dkaṅ” буюу “цагаан” гэсэн үгээс үүдэн ийнхүү үзэж байгаа нь зүйтэй бөгөөд үүн дээр УТНС-ийн 4936 дансанд буй эхэд гурван эх тэнгэрийг “khro ming”, ах дүү есөн үнэгний нэрийг төвд бичгээр хадсан, Үнэгний эх сайхан улаан үнэгийг “Mar san /t. dmar bzang/” хэмээн нэрлэсэн зэргээс үзвэл хэдийгээр төвд эх нь олдоогүй ч уг судрыг төвд хэлнээс орчуулсан нь ойлгомжтой байна. Судрын агуулгын талаар бусад судлаачид дэлгэрэнгүй бичсэн учир товчлон зарим нэг санал зөрөлдөөнтэй байгаа зүйлийн талаар саналаа хэлье.

1. Сударт галиглан буулгасан “madig(midag, mideg, madag)” хэмээх үгийг Ч.Бауден төвд хэлний “me bsreg pa” буюу “гал асаах” гэж тайлбарласан бол У.Эрдэнэтуяа “me gtang” буюу “гал тавих”, эсвэл “me theg” буюу “галын өргөл” гэсэн үг байх хэмээн санал дэвшүүлжээ.¹ Үүнээс үзэхэд дээрх хоёр судлаач энэ үгийг “сангийн гал” буюу “тахилын гал” гэсэн утгаар ойлгож тайлбарласан нь илт байна. Бидний бодлоор энэ үг нь төвд хэлний “ma dag, me dag” гэсэн үг байж болох юм. Учир нь хоёр хувилбарын аль нь ч “ариун бус” гэсэн үг бөгөөд “ариун бус зүйлээр тахил өргөх” гэсэн утга илэрхийлнэ. Сударт, “... Тэр Гүнзи хан өгүүлбэй. Ямарваа энэ үйл нь үнэгнээс болсон амуй. Магад зохиюу. Хороор хорыг гаргаж / өөр хувилбарт мууг муугаар С.Б/ нүгэлт үнэгийг барьтугай, ацартугай” хэмээсэн үүнээс үнэгнээс үүдсэн шалтгаант бузрыг мөн бузар зүйлээр/ madag/ дарах гэсэн утгыг ойлгож болох юм. Сангийн үнэг “Намайг бүү ал, Албаас хилс минь их, Огоот хэрэв албаас би Эсрэн тэнгэрийн есөн бэлгэ төгссөн тул ариун тахил болгон газар тэнгэрийг тахь” хэмээсэн үгнээс удмын нүглээс болж хилсдэн тахил болохдоо өөрийн есөн бэлгийг дуудан “мадаг” бус, “ариун тахил” болгож байгаа нь тодорхой байна.

2. Санд “Хүний хөвгүүдэд эрхэт тэнгэр ивээн хашаан болж эс чадав. Масанг нэрт тэнгэрт өөдгүй үг өгүүлэв” хэмээсний Масанг тэнгэрийн нэрийг олон хувилбарт янз бүрээр “masig, misig” гэхчлэн тэмдэглэснийг судлаачид тайлбарлаагүй. Энэ үгийн утгыг эртний төвдийн домогзүйн дурсгалаас үзвэл, Масанг хэмээх тэнгэр нь Бон шашны уулын тэнгэр, Төвдийн өвөг тэнгэрийн нэр бөгөөд зоо-антропоморф / хүн-үхэр/, антропоморф / өвгөн хүн, шувууны өдөн цувтай, нум сум агссан баатар/ дүртэй дүрслэгддэг², Энэ домгийн монгол хувилбар нь “Ам цагаан бяруу” хэмээх домог үлгэр бөгөөд долоон бурхан одны домог юм. В.Хайссиг, Ч.Бауден нар санд

¹ У.Эрдэнэтуяа . “Үнэгэн сангийн нэгэн судрын тухай”. “Түүхэн судлал” УБ., 2002

² “Мифы народов мира” М., 1998 стр. 508

дурдагдаж буй “Долоон догшин од” гэдэг үгийг “ Долоон гараг”, “Долоон өвгөн” хэмээн тайлбарласан. Тэгэхээр Масанг гэдэг нэр нь энэ долоон догшин одны буюу Долоон өвгөн / Шанага долоо, долоон бурхан, долоон бяруу / бүрүү// одны нэр болох юм.

3. Зургаан зүйлийн эцэг шувууны хан гэсэн ойлголт буйг цаашид нягтлууштай. Эртний Төвдийн хаант улс үүссэн Доод Ярлун мөрний хөндийд нутаглаж байсан овог аймгийн тотем нь шувуу байжээ. Энэ шувуун тотемын төрх нь Төвдийн анхны хаан Ньяти цэн пог шувуун нүд, оюу хөмсөгт, лавай шүдэт, барс сахал, гарын салаа нь галуу лугаа адил сарьстай хэмээсэн дүрслэлд шингэжээ³.

Мөн Бонгийн шашны “си” хэмээх шулмын төрөлтөн дээдэс / Төвдүүд өөрсдийгөө уулын шулам, сармагчин хоёрын дундаас гарсан гэж үздэг. С.Б/ ийн эр нь “Хугархай жигүүрт тэнгэрийн хар шувуу, эм нь газрын жигүүрт харх байсан” гэдэг домог бий. Иймээс “шувууны хан” гэсэн ойлголтын үндсийг төвдийн эртний тотемоос хайх нь зүйтэй болов уу.

4. Ачит Гүнзи хааны / gungji, gunda, gunggezze, gunggi, / нэрийг судлаачид олон янзаар тайлбарласан байдаг. Х.Серриус “gong tsii” буюу “ваар бумба, шавар ваар”, У.Эрдэнэтуяа “kun *dzin” буюу “хамгийг баригч” “газар” хэмээн тайлбарлажээ. Энэ нэрийг Хятадын эртний гүн ухаантайн Күнзийн нэртэй холбон тайлбарласан хүмүүс ч байна. /Д.Ганболд. Монгол сан тахилын судар үгийн урлагийн туурвил болох нь. “Аман зохиол судлал” 2001 он, 23 боть х 112/

Энэ нэр нь Манзшир бурхны нэгэн алдар бололтой. Учир нь, дурдсан хувилбар судрын эхний мөргөлийн хэсэгт лам гурван эрдэнээс гадна зөвхөн Манзшир бурхныг дуудан итгэл явуулсан байхад нэгэн хувьбарт “ gje gong tsii” д мөргөсөн байгаа нь Манзшир бурхныг Гонзи хэмээдгийн жишээ юм.

Судрын агуулгаас ажиглавал, дээр өгүүлсэнчлэн энэ сан нь буддын шашны мөш нимгэн түрхэц бүхий Бон шашны бузар арилгах зан үйлийн судар болно. Дээд монголын Сүмба хамба Ишбалжир /1704-1788/ 1782 онд “Норов гэдага” буюу “Тунгалагжуулагч чандмань эрдэнэ” алдарт зохиолоо бичиж Бурхан багшийн айлдлыг “ Ганжуур” нэрээр эмхтгэх үед Бонбын шүтлэгийн зүйлийг оруулж гутааж булингартуулсныг шүүмжлэн хорьж байсан.⁴ Эртний Төвдөд Бон Буддизм хоёр ихэд холилдсон боловч Бон нь арга засал, зан үйл талаараа голлодог тухай Туган Дармабазар “Бонгийн думтаа”-даа бичсэн нь бий⁵. Ийм номын нэг нь “Үнэгний сан” буй заа.

Дашрамд өгүүлэхэд үнэгийг бузар муу хэмээх үзэл Төв Азийн олон ард түмэнд тархмал байдаг байна. Якутын анчид үнэг агнаад голомтын галд харуулахгүй гэж далдлан гэртээ авч ордог, галын гэрэл шууд тусахгүй газар арьсыг нь өвчдөг заншилтай байжээ.

Монголчуудад үнэгтэй холбоотой заншил, зан үйл бий боловч шүтлэгийн хэмжээнд хүрч хөгжөөгүй мэт санагдана. Монгол ардын билэг зүйн дурсгалаас үзэхэд үнэгний талаарх үзлийг хоёр хувааж болж байна.

Үүнд: Үнэгийг ухаантай зальтай гэж үзэх явдал дэлгэрмэл байна. Монгол ардын үлгэрийн эртний гаралт хэсэг болох адгуусан амьтны үлгэрт үнэг чухал байр эзлэх баатар юм. Заль мэхийг оюун ухаанаас ялгадаггүй байсан балар үеэс үнэг уран сэтгэмжийн баатар болжээ. Тэрээр уран ухааны хүчээр, хүч чадалдаа эрдсэн, мунхаг, бардам чоно, баавгай, барс, арслан зэргийг чадаж, өнчин хүүг Хурмастын охинтой гэрлүүлж, ядарсан хүнд тусалж байна. Гэвч энэ үнэг нь ерийн байгалын зальт үнэг байна.

³ “Мифы народов мира” М., 1998 стр. 509

⁴ Л.Хүрэлбаатар “Судар шастирын билэг” УБ., 2002. 97 тал

⁵ Туган Дармабазар “Туган думтаа” УТНС-ийн гар бичмэл номын фонд

“Бурхан багш 61 мэхийг бүтээхэд олон мэхийг бултыг авъя гэж үнэг их улайж байжээ. Гэтэл бурхан 61 мэхийг хоёр хөлт хохимойд /хүнд/ өгье гэсэн учир үнэг 60 мэх хүртсэн ажээ. Хүн үнэгнээс 1 мэхээр илүү учир үнэгийг агнадаг болсон гэнэ. Үнэг мэхээ хүнд алдсан учир үхэхдээ их хараал хийдэг гэнэ. Хүн үнэг агнахдаа хараалаас айж танигдахгүй гэхдээ өрөөсөн нүдээ аньдаг гэнэ”⁶ хэмээн домоглодог. “Үнэг үнэхээр зальтай, хурдан, бараг хүзүүнийхээ өргөнтэй адил сагсгар сүүлтэй, түүгээрээ анд анх гарч буй туршлагагүй залуу нохойг хамраар нь газар хатгатал хуурч чаддаг ...”⁷ гэж хашир анчид ярианд олонтоо таарна. Энэ чадварыг нь ард түмэн үнэгийг заль мэхтэй, ухаантай гэж үзэх үндэс юм. Иймээс “Үнэг хуураач, нохой шарваач” гэсэн үг гарсан байна. Үнэгийг дээд зэргийн зальтай, ухаантай гэж үзэх энэ үзэл цагийн аясаар хуучран “үнэгэн заль” хэмээх үг нь “бүтэлгүй, даруй баригдах, муухан заль” гэсэн утгатай болжээ.

Үнэхээр ч алдаж буудаад зугатаалгасан үнэг анчинг хараагүй тохиолдолд ганц хоёр гүвээ хамрын цаадтай хулгана агнаад явж байх нь олонтаа. Энэ нь түүний гэнэн, мартамхай амьтан болох тухай анчдын яриа нотолж байна.

Үнэгээр нялх хүүхэд сахиулах ёс монголчуудад эртнээс уламжилж ирсэн байна. Ардын аман тайлбарт хүүхэд зүүдэндээ өмөлзөн уйлагнах, инээмсэглэх зэргийг монголчууд үнэгчлэх гэж нэрлэнэ. Учир нь, хүүхдийн зүүдэнд үнэг ирээд “ээж чинь үхсэн” гэж хуурахад хүүхэд уйлж, “худлаа” гэхэд баярлан инээдэг гэдэг. Иймээс хүүхдийн нойрыг сахиулж дээр нь эсгийгээр бяцхан үнэг хийж өлгөдөг. Жинхэнэ үнэг хүрч ирээд “Энэ хүүхэд үнэгтэй учир хуурч болохгүй юм байна” гээд явдаг гэнэ.⁸ Энэ ёс нь үнэгийг нойр багатай, сэргэг гэсэн утгаар нь хүүхдийн нойрыг сахиулдаг байж болох юм. Одоо ч монгол хэлэнд “Үнэгний нүд залгих” гэсэн хэлц үг нь нойронд сэргэг, унтахгүй байх гэсэн утгатай үг юм.

Монголчуудын ан агнуурын ёсонд агнасан үнэгний арьсаар ангийн хишиг даллах зан үйл байна. Үнэгийг туламлан өвчөөд, сарьсан хамарт нь тулгаж арьснаас нь барьж эргүүлэн дугтарч махнаас нь салгаад

“ Алтай Хангай минь

Үнэгнийхээ улаан

Чонынхоо цагаан

Мануулынхаа эрээнээс хайрла. Хурай Хурай” хэмээн далладаг.

Түүнчлэн үнэгийг далдын муу хүчтэй холбоотой гэж үзэх үзэл бий юм. В.Хайсиг буриадууд үнэгийг эрлэгийн элч хэмээн үздэг байсан тухай тэмдэглэжээ. Ингэж үнэгийг хүмүүн бусын хүчтэй холбон тайлбарлах нь Хятадад үнэгний шүтлэг болон хөгжсөн бөгөөд энэ нь ч монголын ард түмний үзэлд зохих тусгалаа олсон байна.

Хятадын ард түмний уран сэтгэмжид гэм хор багатай энэ амьтан сарны туяанд гэрэлтэн улбалзах, хүүрийг ч болов амьдруулах чадалт, мөнхийн үрлийг хадгалагч, мөнх насны нууцыг мэдэгч, ямар ч дүрд илт хувилах хувилгаан чадалт, хүн төрөлхтөний амьдралд хөндлөнгөөс оролцон гай зовлон удах төдийгүй, аз жаргал, эрүүл энхийг ч хайрлан чадах шидэт амьтан болж хувирсан байна⁹. Хятадын домогзүйд үнэгэн шулам хүнийг хүмүүн бусын гоо үзэсгэлэнгээрээ эзэмдэн татаж, амьдрах шим шүүсийг сорон авч үхүүлээд шинэ анд гардаг, үүнийхээ дүнд урт насалж мянга насалбал мөнх амьдарлын хутгийг олдог хэмээн дүрслэгдэнэ. Гэвч тэр үргэлж мууг үйлдэхгүй бүдүүлэг тэнэг хүмүүсийн толгойг эргүүлэн хуурамч, шунахай, сувдаг итгэл найдвар хөсөрдүүлэгчдийг шийтгэн цээрлүүлэгч болдог байна.¹⁰ Хувилгаан үнэгний тухай анхны мэдээ Чжоу улсын үед МТӨ 791 онд тэмдэглэгдэн үлдсэн байна.

⁶ Х.Цэрэнсодном. “Монгол ардын домог үлгэр” УБ., 1989 91 тал

⁷ Ж.Дамдин. “Буурал анчны тэмдэглэл” УБ., 1975

⁸ Х.Сампилдэндэв “Малчин ардын зан үйлийн уламжлал” УБ.,

⁹ “Рассказы Ляо Чжяя о необычайном” М., 1988 стр 20

¹⁰ “Рассказы Ляо Чжяя о необычайном” М., 1988 стр 20

Оросын академич В.М.Алексееваг 1807 онд Хойт Хятадын нутгаар аялан явахад аль нэг уул толгод, хуучин сүмийн дэргэд “хаан үнэгний” амьдрах нүхний өмнө элдэв эд зүйл, шүтлэг бэлгэдлийн элдэв бэлгэ тэмдэг, бүхий эртний сав суулга тавьсан тахилын ширээ олонтоо тохиолдож байсныг тэмдэглэж үлдээсэн байна.¹¹

Ингэж сонгодог маягаар хөгжсөн үнэг шүтлэг нь хөрш зэргэлдээ Монголчуудын билэг зүйд тусгалаа олсон нь аман зохиол, зан үйлийн олон баримтаар нотлогдож байна. Монгол ардын баатарлагийн тууль, шидэт үлгэрт мангас, ялангуяа шулмас үнэг болон хувилах явдал олонтоо гарч байна.

“ Гурван ногоон торгон дээлтэй хүүхэн

Гурван галт хар үнэг болж зугатахад...”

“ Баруун наран шингэх зүгийг эзлэн төрсөн

Далан эвэртэй догшин хар морьтой

Дөш хар мангас

Гурнаан хөх үнэг болж

Гурван муу ёрыг ёрлон

Албат хошууны минь дундуур гүйхэд

Харван алж байна”

“ Ухархай ясны дунд хэвтсэн тал хөх хомоолын авч

Хоёр гурав шившин хурдан түргэн шатаах гэтэл

Гурнаан хөх үнэг болоод гүйж гараад давхихлээр

Хоёр сайн баатар дүү нь мухар нүхэнд хөөн оруулаад

Хуйхалж түймэрдээд шатаав.¹²

Монгол ардын үлгэрт ... Анчин авгайн захад байдаг жаахан эхнэр манай энэ ууланд шулам болоод хоёр гурван жил болжээ. Зарим өдөр цагаан нэг болоод явдаг, зарим өдөр нэг сайхан эхнэр болоод хүн амьтны сүнсийг авдаг, зарим өдөр чөтгөр болж түмнийг айлгадаг.”

“Хатан үнсэн дээр очиж хөрвөөгөөд урт улаан үнэг болчихоод зүүн хойш давхижээ.” гэх мэтийн олон жишээ олж болох юм. Дашрамд хэлэхэд монгол домогзүйн үнэгэн шулам хятадаас өөр, монгол ахуйд зохицсон аж. Үүнд, Үнэг үнсэн дээр хөрвөөх, Ухархай ясны дунд хомоол болон хэвтэх зэрэг ба хятадын домог зүйд үнэг хүн ба бусад амьтан болж хувирдаг бол монгол домогзүйд шулмас үнэг болон хувирч байдаг онцлогтой. Үүнээс үндэслэн монголчууд үнэг хуцахыг маш муу ёр хэмээн үздэг байжээ.

Анчид аянчдын замд үнэг тааралдвал ёрлон үзэж заавал алахыг хичээдэг, эс чадваас ажил бүтэхгүй гэж үзнэ. Баруун монголчууд ийм үед дээлээ тайлж захыг нь доош харуулан үсийг нь эргүүлэн гурвантаа сэгсэрч домнодог ажээ¹³.

Монголын анчдын дунд үнэг агнаад мөчийг нугалж гэдсийг гарган унжуулж унасан зүг рүү толгойг нь харуулж нохой шиг цагариглуулан хэвтүүлж орхидог тухай академич Х.Пэрлээ агсан тэмдэглэн үлдээсэн байдаг. Урианхайн анчид ч үүнтэй төстэй үнэгний хойд хоёр борвийг нүхлэн, урд хөлийг нугалж, хүзүү нурууны судас шөрмөсийг огтлон орхидог ажээ. Ингэхгүй бол үнэг суманд дийлдэхгүй аймшигт араатан болж босон хүн малд гай учруулна гэдэг.

Дээр өгүүлснээс дүгнэн үзвэл,

- “Үнэгэн сангийн судар” нь буддын шашны нөлөө туссан төвдийн Бон шашны судар гэж үзсэн судлаачидтай санал нэг байна.

¹¹ “Рассказы Ляо Чжяя о необычайном” М., 1988 стр 22

¹² Г.Ринченсамбуу “Монгол ардын баатарлагийн тууль” УБ.,

¹³ М.Ганболд “Алтайн урианхайн шүтлэг” УБ., 2000. 138 тл

- Төвдийн домогзүйн дурсгалд тулгуурлан “мадаг” гэдэг үгийг “ариун бус”, “Масанг” хэмээх нэрийг Долоон бурхан одны нэр, “Гүнзи” хааны нэрийг Манзшир бурхны нэр хэмээх санал дэвшүүлж байна

- Шувууны хаан гэсэн ойлголт нь эртний төвдийн тотем шүтлэгтэй холбоотой нэр томъёо байж болзошгүй.

- Сангийн сударт гарч буй үнэг нь төвдийн бэлгээгүйн дүр , огторгуйн үнэг учир монгол ахуй сэтгэлгээний үүднээс тайлбарлах учир дутагдалтай юм.

- Монголчуудад үнэгтэй холбоотой олон зан үйл байгаа боловч үнэг нь шүтлэгийн амьтан болоогүй байна.

- Монголчуудын үнэгний тухай үзэлд Хятадын үнэг шүтлэгийн ёс нэлээд нөлөөлсөн ч үнэгэн шулмын дүр нь монгол ахуйд зохицон нэлээд өөрчлөгдсөн байна.

Резюме

С.Бямбадорж

В статье автор рассматривает сутру “үнэгэн сангийн судар” получившая от прежних исследователей трактовку по четырем разным категориям, и предлагает новую дефиницию, проводит сравнительное исследование с китайским и тибетским культами лис. На основе сравнительного анализа выясняет монгольские народные обряды связанные с лисами и их трансформацию